

МОНЦАМЭ-ГИЙН ХЭВЛЭЛҮҮДИЙН УЛАМЖЛАЛ БА ШИНЭЧЛЭЛ, ТУЛГАМДСАН ЗАРИМ АСУУДАЛ

Т.Баасансүрэн*

* МОНЦАМЭ агентлагийн захирал, түүхийн ухааны доктор (Ph.D.)

Түлхүүр үг: мэдээллийн агентлаг, гадаад сурталчилгаа, гадаад хэл дээрх хэвлэл, "МОНЦАМЭ-гийн Алтан дүрэм", социологийн судалгаа, уншигчдын хандлага, нийтлэлийн үр нөлөө.

Монгол Улсын мэдээллийн МОНЦАМЭ агентлаг 1921 оны 7-р сарын 19-нд үүсэн байгуулагдаж үйл ажиллагаагаа эхэлсэн түүхтэй билээ. 1922 оноос тус агентлаг "Бюллетень Монгольского Телеграфного Агентства" сониныг орос хэл дээр, "Хураангуй сэтгүүл" сониныг монгол хэл дээр зэрэгцүүлэн гаргаж эхэлжээ.

"Бюллетень Монгольского Телеграфного Агентства" сониныг 1922 оны 5-р сарын 25-наас Монголын цахилгаан мэдээний агентлаг МОНТА-гаас эрхэлж 7 хоногт хоёр удаа орос, монгол хэлээр гаргаж эхэлсэн байна. Монголд үүссэн мэдээллийн агентлаг үйл ажиллагаагаа гадаад хэл дээр сонин гаргахаас эхэлж, тухайлбал орос хэл дээр гаргах мэдээллийг чухалчлан үзэж байсан нь гадаадын улс орнуудын мэдээллийн агентлагуудын үүсэл хөгжлийн ерөнхий зүй тогтол, чиг хандлага, жишигтэй нийцэж байсныг баталж байгаа юм. Монгол Улс, монголчуудын тухай үнэн

бодит мэдээллийг гадаад ертөнцөд шуурхай дамжуулах нь үндэсний мэдээллийн агентлагийн үндсэн зорилтын нэг байдгийг энэ баримт бас давхар баталгаажуулж байгаа болно.

2002 оны байдлаар Улсын төв номын санд 1922-1923 онд монгол бичгээр гаргаж байсан "Хураангуй сэтгүүл"-ийн дугаар ердөө 20-хон, харин "Бюллетень Монгольского Телеграфного Агентства" сонины 1922 оны 27 дугаар, 1923 оны 36 дугаар хадгалагдаж байв. Бусад дугаар нь үрэгдэж алга болоод олдохоо байсан байлаа. Тэдгээрийг орчин цагийн кирилл үсэг рүү бүгдийг хөрвүүлэн буулгаж уншигчдын хүртээл болгосон нь тухайн цаг үед хийсэн зөв зүйтэй, маш чухал ажил байсан юм. (Сүүлд ахин эмхэтгэж "XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл" цувралын тэргүүн дэвтрийн II хэсэгт бүрэн эхээр оруулсан билээ). Гол төлөв нимгэн муутуу цаасан дээр хэвлэн гаргаж байсан дээрх хоёр сониныг гэрэл зурагт мөнхлөн буулгаж авахаар 2008 онд Улсын нийтийн төв номын санд очиход үлдсэн дугааруудын олонх нь ор сураггүй болсон байв. Бүтэн өдөр эрж хайж байж нэгэн дугуйн дотроос цөөн дугаарыг олж гэрэл зурагт буулгаж авсан болно.

Эдгээр сонины дугааруудын үнэ цэнийг өнөөдөр юутай ч зүйрлэх аргагүй бөгөөд Монгол Улсын тухайн цаг үеийн үнэн бодит байдал, хүн ардын аж амьдрал, ахуй заншил, түүх соёлын талаарх хамгийн өргөн цар хүрээтэй мэдээллийг өгч чадаж байгаа юм. Энэ тухай миний бие "Бюллетень Монгольского Телеграфного Агентства" сонины 1922-1923 оны дугааруудын нийтлэлийн байдалд хийсэн шинжлэл"¹ өгүүлэлдээ дэлгэрэнгүй өгүүлсэн тул энд дахин давтаж нуршихгүй. Онцгойлон дурдсаны учир гэвэл нэгд, мэдээллийн МОНЦАМЭ агентлаг бүр 1922 оноос өөрийн сонин хэвлэлийг гаргаж эхэлснийг, хоёрдугаарт, гадаад хэл дээрх сурталчилгааг Монголд анх түрүүлж эхлүүлснийг цохон тэмдэглэхийг хүссэнд билээ.

Өөрөөр хэлбэл Монголд сэтгүүл зүйн мэргэжлийн төвшин дэх гадаад сурталчилгаа эхлээд бас ерээд жилийн нүүр үзэж байна гэсэн үг юм. Мэдээллийн МОНЦАМЭ агентлаг гадаад сурталчилгааг дангаараа эрхэлсээр эдүгээг хүргэжээ. Өнгөрсөн хугацаанд мэдээллийн МОНЦАМЭ агентлагаас гадаад сурталчилгааны чиглэлээр:

- "Бюллетень Монгольского Телеграфного Агентства" сониныг 1922 оноос орос, монгол хэлээр;

- "Ажилчны зам" сониныг 1929 оны 9-р сарын 1-нээс хятад хэлээр (эхний үед МҮЭ-ийн Төв зөвлөлөөс гаргаж байв);

- "Монголын мэдээ" сониныг 1964 оноос хятад хэлээр;

- "Новости Монголии" сониныг 1942 оны 5-р сарын 1-нээс орос хэлээр;

- "Монголия" сэтгүүлийг 1956 оны 7-р сараас орос хэлээр;

- "Mongolia" сэтгүүлийг 1965 -1980 онд англи хэлээр;

- "Монгол мессенжер" сониныг 1991 оноос англи хэлээр;

- "Монгору цушин" сониныг 2003 оноос япон хэлээр;

- "Mongolia today" ("Өнөөгийн Монгол Улс") улирал тутмын сэтгүүлийг 2006 оноос англи хэлээр тус тус гаргаж ирсэн байна.

Үүн дээр МОНЦАМЭ агентлагаас өдөр тутам орос, англи хэлээр хэвлэн түгээдэг "МОНЦАМЭ-гийн мэдээ" товхимлыг нэмж хэлэх хэрэгтэй. Эдгээр товхимлыг 1991 оноос эдүгээг хүртэл тасралтгүй гаргаж байна. Мөн хамтын ажиллагааны гэрээ, протоколтой ажилладаг Ази, Номхон далайн улс орнуудын мэдээллийн агентлагуудын нэгдсэн байгууллага ОАНА болон дэлхийн бусад улс орнуудын гучаад мэдээллийн агентлагуудад өдөр тутам англи ба орос хэлээр хүргүүлж буй мэдээ мэдээлэл нь Монгол Улс, Монголын ард түмнийг гадаадад үнэн бодитойгоор сурталчлах үндсэн гол гүүр болж байна.

Дээр дурдсан хугацаанд Орос-Монголын хэвлэлийн хороо, Орос-Монголын клубээс 1924-1928 оны хооронд "Известия", 1926-1931 онд "Хозяйство Монголии" хэвлэл, Улаанбаатар дахь Лениний нэрэмжит клубээс 1933-1940 оны хооронд "Современная Монголия" сэтгүүлийг орос хэлээр гаргаж цөөхөн хувиар гол төлөв Монголд тарааж, Монгол Улстай ажил хэргийн холбоотой Оросын иргэдэд хүргэж байсныг эс тооцвол гадаад сурталчилгааны өөр сонин, сэтгүүл байгаагүй болно. Харин 1964 оноос Монголын өргөн нэвтрүүлгийн радиогоос

эрхлэн "Монголын дуу хоолой" радио станцийг байгуулж орос, хятад зэрэг түгээмэл гадаад хэлээр нэвтрүүлэг цацаж эхэлсэн нь манай гадаад сурталчилгаанд жинтэй хувь нэмэр оруулах болсон билээ.

Ө нөөдөр МОНЦАМЭ агентлаг өдөр тутмын "МОНЦАМЭ мэдээ" сониныг 16 нүүрээр хэвлэн гаргаж Монгол Улсын нийслэл Улаанбаатар хот, 21 аймагт тараан түгээж байна. Нийт улс орны хэмжээний амьдрал, ажил үйлс "МОНЦАМЭ мэдээ" сонинд хамгийн өргөн бодитойгоор тусгалаа олдог юм. Учир нь МОНЦАМЭ агентлагийн тусгай сурвалжлагчид 21 аймагт ажиллаж өдөр тутам хэдэн арван мэдээ мэдээллийг агентлагтаа ирүүлж, "МОНЦАМЭ мэдээ" сонинд нийтлүүлж байна. Орон нутгийн ажил үйлсийг ийм дэлгэрэнгүйгээр тогтмол нийтлэдэг хэвлэл Монголд өөр байхгүй. "МОНЦАМЭ мэдээ" сонины нэг дэх онцлог энэ. Хоёрт тэдгээр мэдээ мэдээллийн товч хураангуйг МОНЦАМЭ агентлаг өдөр тутам англи болоод орос хэлээр гадаадын мэдээллийн агентлагуудад илгээж байдаг юм. Өөрөөр хэлбэл Монгол Улс, Монголын ард түмний ажил үйлсийг гадаад ертөнцөд тасралтгүй сурталчилж байна гэсэн үг юм. Гуравт, дэлхий дахинд болж байгаа үйл явдлыг МОНЦАМЭ агентлаг өдөр, шөнийн 24 цагт тасралтгүй хүлээн авч эх монгол хэл рүүгээ хүрвүүлээд "МОНЦАМЭ мэдээ" сонинд болон Монголын бусад бүх хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдэд нийлүүлж байна. Эдгээр мэдээ, мэдээлэл нь хамгийн үнэн бодитой бөгөөд баталгаатай эх сурвалжаас авсан байдаг гол онцлог нь оршдог юм.

Одоогоос ерээд жилийн өмнө "Хураангуй сэтгүүл" буюу "Бюллетень Монгольского Телеграфного Агентства" нэрээр монгол, орос хэлээр гарч байсан Монголын ууган хэвлэлүүд нь өнөөдөр "МОНЦАМЭ мэдээ" нэрээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлж байна гэж ойлгож болно. Өөрөөр хэлбэл "МОНЦАМЭ мэдээ" сонины эх ундарга, уг сурвалж нь "Хураангуй сэтгүүл", "Бюллетень Монгольского Телеграфного Агентства" сонин мөн.

МОНЦАМЭ агентлаг "Хураангуй сэтгүүл"-ийн үнэт уламжлалыг хадгалж 18 жилийн өмнөөс буюу 1992 оны 5-р сарын 10-наас монгол бичгээр "Хүмүүн бичиг" сониныг 7 хоног тутам гаргаж эхэлсэн билээ. Ийм хэвлэл Монголд ердөө цорын ганц байдаг юм. "Хүмүүн бичиг" сонин Монголын ард түмний бичиг соёлын их түүхийг өртөөлөн залгамжилж эдүгээ хийгээд ирээдүй хойч үеийнхнийг холбоход үнэлж баршгүй том хувь нэмрийг оруулж байна.

Үүнээс гадна МОНЦАМЭ агентлаг "Монгол мессенжер" сониныг англи хэлээр, "Менгу сяосибай" сониныг хятад хэлээр, "Новости Монголии" сониныг орос хэлээр, "Монгору цушин" сониныг япон хэлээр долоо хоног тутам, "Mongolia today" ("Өнөөгийн Монгол Улс") сэтгүүлийг улирал тутам гаргаж байна. Эдгээр хэвлэл нь Монгол Улс, Монголын ард түмний түүх, соёлын уламжлал шинэчлэл хийгээд ардчилсан өөрчлөн байгуулалтын үнэт зүйлсийг гадаад ертөнцөд үнэн бодитойгоор сурталчлан таниулах манай гол эх сурвалж болж байна.

МОНЦАМЭ агентлагаас хэвлэн гаргаж байгаа эдгээр сонин, сэтгүүлийн нийтлэлийн үр нөлөөнд үнэлэлт дүгнэлт хийх зорилгоор, хамгийн гол нь нэр

бүхий дээрх хэвлэлүүдийг цаашид үргэлжлүүлэн гаргах нь зүйтэй юу, үгүй юу гэдэг асуудлаар голлож МСНЭ, МУИС-ийн сэтгүүл зүйн тэнхимтэй хамтарч 2009 онд уншигчдын дунд социологийн судалгаа явуулсан юм. Түүний дүнгээс танилцуулъя.

Хялбаршуулсан анкетын судалгаанд нийслэл Улаанбаатар хот болон 17 аймгийн 814 хүн хамрагджээ. Тэдний 429 нь эрэгтэй, 385 нь эмэгтэйчүүд байна. Насны байдлаар ангилж үзвэл 16-25 насны 150, 26-35 насны 264, 36-45 насны 181, 46-55 насны 145, 56-гаас дээш насны хүн 74 байна. Тэднээс 589 хүн нь дээд боловсролтой, 49 нь тусгай дунд боловсролтой, 157 нь бүрэн дунд боловсролтой, 19 нь бүрэн бус боловсролтой хүмүүс ажээ. Судалгаанд хамрагдсан эдгээр иргэдээс 731 нь буюу 89,8 хувь нь "МОНЦАМЭ мэдээ" сониныг цаашид үргэлжлүүлэн гаргах нь зүйтэй гэж үзжээ. 20 хүн буюу 2.4 хувь нь ийм сонин байх шаардлагагүй, 63 хүн буюу 7.7 хувь нь мэдэхгүй байна гэж хариулсан байна. Үүнээс үзвэл "МОНЦАМЭ мэдээ" сонин өмнөө тавьсан үндсэн зорилгоо ямар нэгэн байдлаар биелүүлж байна гэж хэлэх үндэслэлтэй байна.

Өдөр тутмын оройн сэтгүүлийн хэлбэрээр тасралтгүй 5 жилийн турш хэвлэгдээд 2008 оны сүүлчээс өдөр тутмын сонины хэлбэрт шилжсэн "МОНЦАМЭ мэдээ" хүмүүст хүрч, тэдний мэдээ, мэдээллийн эрэлт хэрэгцээг хангаж байгаа нь харагдаж байна. УИХ-ын гишүүнээр олон удаа сонгогдож, 2008 оноос Монгол Улсын Засгийн газрын гишүүнээр ажиллаж байгаа Монгол Улсын Нийгэм, Хөдөлмөр Хамгааллын сайд, мэргэжлийн сэтгүүлч

Т.Ганди "МОНЦАМЭ мэдээ" сонины нэгэн нийтлэлтэй холбогдуулж өөрийн санал бодлоо хэлжээ. Түүндээ "Бүх зүйл МОНЦАМЭ-гийн мэдээнээс эхэлсэн хэрэг. Мэдээж хэрэг албан хэрэгцээнд захиалан уншдаг сонин хэвлэлээс "МОНЦАМЭ-гийн мэдээ"-нд ач холбогдол өгч, ямар ч цаг завгүй байсан нэг гүйлгээд харчих санаатай байдаг хүн, би. Эх орны өнцөг булан бүрийн, аймаг, сум, баг, бригад, тосгон, суурин гэхгүй улсынхаа талаар яаж ийгээд бүрэн бүтэн цогц мэдээлэл авчихдаг учир тэр байх. "МОНЦАМЭ-гийн мэдээ"-г харжээ суутал Хэнтий аймгийн Өндөрхаанаас сурвалжлагч Б.Адьяахүүгийн бичсэн жижигхэн мэдээ анхаарал татав. "Солонгос эмэгтэй ядарч явна" гэсэн гарчигтай байсан санагдаж байна. Солонгосын дайны дараахан манай улсад 100 гаруй өнчин хүүхэд ирж, хүүхэд асрах газарт өсөцгөөж хожим олонх нь буцсан бөгөөд арваад хүүхэд нь монгол айлд үрчлэгдэж үлджээ. Энд үрчлэгдэн үлдсэн өнчин хүүхдүүдийн нэг нь Цэрэнханд нэртэй болж амьдралын хүнд хэцүүг туулан явсаар эдүгээ Өндөрхаан хотод ядуу зүдүү амьдарч явааг дурдсан байсан. Цэрэнханд гуай хөгжлийн бэрхшээлтэй охиноо дагуулан халамжийн газраар орж гарч яваатай нь таарсан. Солонгос эмэгтэй ядарч л явна даа гэсэн утгатай бичлэг байсан юм. Дараахан нь Хэнтий ордог юм байна. Ажлаар явсан болохоор цаг хугацаа давчуу, ах дүү, айл амьтнаар орж ч амжсангүй. Гэхдээ хэдэн сарын өмнө уншсан МОНЦАМЭ-гийн мэдээ санааны мухарт нэг юм сануулаад байдаг. Ингээд л хот буцах явдлын замд Цэрэнханд

гуайнхаар ороод гарахаар шийдэв”² гэжээ.

Т.Ганди сайд Ш.Цэрэнхандын хүүг сургуульд, охиныг нь ажилд оруулж өгчээ. Сэтгүүлч Б.Адьяахүүгийн “МОНЦАМЭ мэдээ”-нд гаргасан эл нийтлэл үр нөлөөтэй болсон байна. Бодитой үр дүнд хүрчээ. Энэ бол нийтлэлийн үр нөлөөний тодорхой нэгэн илэрхийлэл мөн.

Аль ч сонин, сэтгүүлийн үндсэн үүрэг бол хүмүүст хэрэгтэй, ашигтай, идэвхтэй мэдээлэл өгөх явдал юм. Иргэд тэрхүү ашигтай, хэрэгтэй шинэ мэдээллийг нь ахуй амьдралдаа авч хэрэглэж байвал сонины нийтлэл үр нөлөөтэй болж байна гэж үзэж болно. Нийтлэлийн-

хээ үр нөлөөг сайжруулах, үр ашгийг нэмэгдүүлэх нь нийт хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчдийн стратегийн зорилт байдаг билээ. Ингэж чадаж байвал сая сонин, сэтгүүл оршин тогтнох эрхээ олж авдаг. “МОНЦАМЭ мэдээ” сонины нийтлэлд уншигчдын зүгээс өгсөн дээрх үнэлэлт дүгнэлт түүнд одоогоор үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах эрхийг олгож байна.

Тэгэхдээ энэ нь бүх зүйл зуун хувь сайн байна гэсэн үг хараахан бишээ. Судалгаанд оролцогчдын 2.4 хувь нь “МОНЦАМЭ мэдээ” сониныг цаашид үргэлжлүүлэн гаргах хэрэггүй гэж үзжээ. 7.7 хувь нь мэдэхгүй хэмээн хариулсан байна. Өөрөөр хэлбэл 814 хүний 10.1

хувь нь “МОНЦАМЭ мэдээ” сонинд шүүмжлэлтэй хандсан байна гэж үзэж болно. Энэ нь тус сонинд тэдэнд зориулсан нийтлэл үгүйлэгдэж байгаа, эсвэл ийм сонин тэдэнд огт хэрэггүй гэсэн үг юм. Үүнд сонины редакци, “МОНЦАМЭ мэдээ” сонинд ажилладаг нийт уран бүтээлчид дүгнэлт хийж ажиллах учиртай. Судалгаанд хамраг-

дагчдаас “Хүмүүн бичиг” сониныг 678 хүн буюу 83.2 хувь нь цаашид үргэлжлүүлэн гаргах хэрэгтэй гэж үзсэн байхад 54 хүн хэрэггүй, 82 хүн буюу 10 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. 20 жилийн өмнөх байдалтай харьцуулахад энэ нь маш өндөр үзүүлэлт мөн боловч судалгаанд оролцогс-

дын 16.6 хувь нь “Хүмүүн бичиг” сонинд шүүмжлэлтэй хандаж байна гэж үзвэл зохилтой.

МОНЦАМЭ агентлагаас гадаадын түгээмэл хэлээр гаргаж буй сонин, сэтгүүлийн талаар урьд өмнө нь социологийн ямар нэгэн судалгаа хийгдэж байгаагүй юм. Тийм судалгаа зохион байгуулах нь ч харьцангуй түвэгтэй бөгөөд ерөнхийдөө жил бүр захиалан ашиглаж буй уншигчдынхаа тоо хэмжээгээр нийтлэлийн бодит байдалдаа үнэлэлт дүгнэлт хийж ирсэн гэж хэлж болно. Энэ удаад монголчуудынхаа дунд дээрх судалгааг явуулахдаа манай иргэдээс улс орны гадаад сурталчилгаанд хандаж буй чиг хандлагыг мэдэж

«

МОНЦАМЭ агентлаг 1992 оны 5-р сарын 10-наас монгол бичгээр “Хүмүүн бичиг” сониныг гаргаж эхэлсэн билээ. “Хүмүүн бичиг” сонин Монголын ард түмний бичиг соёлын их түүхийг өртөөлөн залгамжилж эдүгээ хийгээд ирээдүй хойч үеийнхнийг холбоход үнэлж баршгүй том хувь нэмэр оруулж байна.

»

мэдрэхийг гол зорилгоо болгосон гэдгийг юуны өмнө тэмдэглэж хэлье. Ингэх нь орос, англи, хятад, япон хэлний мэдлэг боловсролтой, тэдгээр хэлээр сонин хэвлэлийг эх хэлтэйгээ адил хэмжээнд ашиглах чадвартай уншигчид төдийлөн олон биш гэдгийг бодолцсонтой холбоотой юм. Тийм учраас судалгаанд хамрагдагчдын хариулт нь эдгээр сонин, сэтгүүлийн нийтлэлийн үр нөлөөг үнэлж, түүнд өгсөн үнэлэлт биш юм. Харин тэдгээр хүмүүсийн иргэний байр суурь, ухамсрын төвшинг ямар нэг байдлаар илэрхийлж тодорхойлсон гэж үзэх нь бодит байдалд илүү нийцэх болно. Өөрөөр хэлбэл Монгол Улсын иргэд гадаад сурталчилгаанд ямар ач холбогдол өгч байна вэ, ер нь МОНЦАМЭ агентлагаас түгээмэл гадаад хэлээр сонин, хэвлэл гаргахын хэрэг байна уу, үгүй юу гэдэгт бид хариулт авахыг зорьсон юм. Судалгааны асуудлууд ч энэ зорилгоор зохиогдсон болно. Түүнд Монгол Улсын нийслэл хот болон 17 аймгийн иргэдийн төлөөлөл өөрсдийн хариултыг дараах байдлаар өгчээ.

Тэднээс 678 иргэн буюу 83.2 хувь нь англи хэл дээрх "Монгол мессенжер" сониныг цаашид үргэлжлүүлэн гаргах нь зүйтэй гэж үзсэн байна. 26 хүн буюу 3.1 хувь нь хэрэггүй, 110 хүн буюу 13.5 хувь нь мэдэхгүй гэжээ. "Новости Монголии" сониныг 666 хүн буюу 81.8 хувь нь үргэлжлүүлэн гаргахыг дэмжиж, 31 хүн буюу 3.8 хувь нь эсэргүүцэж, 117 хүн буюу 14.3 хувь нь мэдэхгүй хэмээн хариулсан байна.

Энэ байдал хятад хэлээр гардаг "Менгу сяосибо" сонины хувьд 67.3 хувийн (548 хүн хэрэгтэй гэж үзжээ) дэмжлэг авч байхад япон хэлээр

хэвлэгддэг харьцангуй шинэ хэвлэл "Монгору цушин" сонинд 66.8 хувьтай байна (544 хүн япон хэлээр сонин гаргах нь ашигтай гэжээ). Судалгаанд хамрагдаас 110 хүн буюу 13.5 хувь нь "Менгу сяосибо" сониныг үргэлжлүүлэн гаргах хэрэггүй, 72 хүн буюу 8.8 хувь нь "Монгору цушин" сонин зайлшгүй биш гэж өөрсдийн санаа бодлоо илэрхийлжээ. Судалгаанд оролцогчдоос 156 хүн буюу 19.1 хувь нь хятад хэл дээр сонин гаргах асуудлаар, 198 хүн буюу 24.3 хувь нь япон хэлээр хэвлэл гаргах асуудлаар тодорхой санал бодлоо илэрхийлээгүй байна. Харин манай судалгаанд хамрагдагчдаас 587 хүн буюу 72.1 хувь нь "Mongolia today" ("Өнөөгийн Монгол Улс") сэтгүүлийг англи хэлээр гаргаж байгааг талархан сайшаажээ. 54 хүн буюу 6.2 хувь нь ийм сэтгүүл гаргахад дургүйцэж, 176 хүн буюу 21.6 хувь нь хэлж мэдэхгүй гэсэн байна.

Санал асуулгын дүнгээс харахад судалгаанд хамрагдсан Монгол Улсын иргэдийн 66.8-83.2 хувь нь ("Монгол мессенжер" сониныг 83.2%, "Новости Монголии" сониныг 81.8%, "Менгу сяосибо" сониныг 67.3%, "Монгору цушин" сониныг 66.8%, "Mongolia today" сэтгүүлийг 72.1% үргэлжлүүлэн гаргах нь зүйтэй гэж үзсэн болно) **МОНЦАМЭ** агентлагаас түгээмэл гадаад хэлээр сонин хэвлэл гаргаж Монгол Улс, Монголын ард түмний түүх, соёлын уламжлал шинэчлэл, ардчилсан шинэ Монгол Улсын өнөөгийн ажил үйлсийг гадаадын уншигчдад үнэн бодитойгоор мэдээлэх зайлшгүй шаардлагатай хэмээн үзэж талархан дэмжжээ. Энэ бол манай иргэдийн эх оронч сэтгэлгээ туйлын

өндөр төвшинд байгааг илтгэсэн гайхамшигтай баримт бөгөөд даяарчлал буюу дэлхийчлэл хүн төрөлхтнийг бүхэлд нь хамарч, Монгол Улс дэлхий ертөнцөд бүрэн утгаараа нээлттэй болсон өнөө үед гадаад сурталчилгааг системтэй, тасралтгүй явуулахын зайлшгүйг цохон тэмдэглэсэн ард нийтийн захиа, даалгавар гэж үзвэл зохистой санагдана. Өнгөрсөн онд нийслэл Улаанбаатар хот болон 17 аймгийг хамруулан зохион байгуулсан социологийн судалгааны гол ач холбогдол үүнд оршино.

Гадаад сурталчилгааны чиглэлээр МОНЦАМЭ агентлагаас гаргаж байгаа сонин хэвлэлийг гадаадын уншигчид ч сонирхон таашааж, өөрсдийн санал бодлоо илэрхийлэх нь цөөнгүй байна. Ганц нэг жишээг дурдахад ОХУ-ын иргэдээс нэг биш хүн “Новости Монголии” сонинд хандаж Монгол маркийн баялаг цуглуулгатай болоход туслахыг хүсч, Монголын ард түмний түүх, соёлын өвөрмөц онцлогоос нийтэлж байхыг санал болгожээ. Украин Улсын иргэн, Киев хот дахь “Монгол клуб” олон нийтийн байгууллагын Ерөнхийлөгч Евгений Григорьевич Горбатенко гуай 2009 оны 3-р сарын 30-нд тус сонины редакцид албан ёсны захидал ирүүлж Украины ахмад дайчдын байгууллага болох “Монгол клуб”-ын үйл ажиллагааны талаар уншигчиддаа мэдээлэл өгөхийг хүссэн байх жишээтэй байна.

Ийм захидал, тодорхой зарим санал хүсэлт бусад сонины газарт ч цөөнгүй ирж байна. Тухайлбал Англи, АНУ зэрэг улс орны иргэдээс “Монгол мессенжер” сонинд хандах нь олонтоо байдаг. Бартоломю Дигби гэдэг хүн “Сүүлийн дугаарт гарсан казахийн боловсролын

тухай “Хүүхэд багачуудыг аваръя” гэсэн илтгэлийн талаар уншихад их сонирхолтой байсан. Одоогоор би Улаанбаатарт судалгаа хийж байгаа бөгөөд уг илтгэлийн эх хувийг хаанаас олж болохыг хэлж өгч тусална уу” гэсэн байхад “Миний нэрийг Роберт Слинн гэдэг. Би Их Британийн хилийн чанадад ажиллах сайн дурынхны нийгэмлэгийн гишүүний хувьд Улаанбаатар хотноо ажиллаж байна. 11-р сарын 9-нд Монголын Үндэсний Сайн дурынхны нийгэмлэгийн уулзалт Нүхтэд болох гэж буйг танай сониноор уламжлан олон нийтэд мэдээлэх, мөн нэг сурвалжлагчаа энэхүү үйл явдалд оролцуулан сонирхолтой сурвалжлага хийж, гэрэл зураг аваасай хэмээн хүсэх үүднээс та бүхэнд энэхүү захидлыг бичиж байгаа юм” хэмээн өөр нэг нь бичсэн байх жишээтэй ажээ. “Сайн байна уу, намайг Берт Профе гэдэг бөгөөд би өнгөрсөн хавар “Монгол мессенжер” сонинд “Хөвсгөл экспедици-2009”-ийн талаар нилээд гайгүй өгүүлэл бичсэн юм. Одоо би та бүхэнд илүү урт өгүүлэл илгээж магадгүй байна. Дараа жилийн 4-р сараас эхлээд аялагч Риплей Давенпорт Монгол Улсыг явганаар хөндлөн гулд аялах гэж байна. Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг www.mongolia2010.com руу орж үзнэ үү” гэж өөр нэг нь саналаа бичжээ.

Ойрмогхон “Монгол мессенжер” сонины газар нэгэн сонирхолтой захидал, хатуухан үгтэй шүүмжлэлийг хүлээн авчээ. Түүнийг би бүрэн эхээр нь сийрүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Уг захидалд:

“Хүндэт Индра, Та бүхэн доорхи захидлыг “Монгол мессенжер” сонины редакторт уламжилж өгвөл маш их

талархах болно. Анхаарал тавьсанд баярлалаа.

Хүндэтгэсэн, Анита Фарни

Хэлзүй болон багшлах чадварыг дээшлүүлэх Швейцарийн хөтөлбөр

Дуулиант цанын цогцолбор

Монгол орны талаар олон жилийн өмнөөс мэддэг болсны хувьд Богд Хан ууланд цанын талбай баригдсан гэдгийг сонсоод миний бие туйлын их цочирдлоо. Хэрвээ би андуураагүй бол Богд Хан уул дархан цаазтай газар шиг санагдах юм. Ийм үйлдэл хийснээрээ уг газрыг дархан цаазтай гэсний утга учир алдагдаж байгаа юм. Уулын нэг хэсэгт аль хэдийнээ барилга байшин босож эхэлжээ. Тэдгээр байшингууд нь бүгд л баян чинээлэг хүмүүсийнх бөгөөд энэ нь мөнгөөр бүхнийг шийдэж болно гэдгийн баталгаа юм.

Энэ байдлаас болж тэртэй тэргүй хэцүүдэж байгаа Богд уулын ой мод, орчин тойронд хохирол учраад зогсохгүй үлдсэн цөөхөн ан амьтад хүндхэн байдал орох болно.

Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд хууль хэрэгжүүлэх явдлыг чангатгаснаар байгаль орчныг хамгаална гэж амласныг би сонссон. Энэ цанын бааз нь түүний амлалтын үнэн эсэхийг батлах зүйл юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын цаг агаарын өөрчлөлтийн тухай хийсэн чуулган дээр Монголын төлөөлөгчдийн хийсэн мэдэгдэл үнэн эсэхэд эргэлзэж сууна.

Монгол Улс дэлхий дахиныг өөртөө татах хамгийн гол зүйлсийн нэг болох үзэсгэлэнт байгаль орчноо сүйтгэж байна хэмээн бодож байна. Анита Фарни" гэсэн байна. Монгол орны

хүрээлэн байгаа байгаль орчин, дархан цаазат Богд уулын төлөө монголчууд биднээс илүүтэй ихээр санаа зовинооно бичжээ. Гэтэл Монголын сэтгүүлчид бид болохоор Богд ууланд дэлхийн төвшин, стандартад нийцсэн орчин үеийн цанын тохилог баазтай боллоо гээд л хөөрцөглөөд сууж байгаа билээ.

Японы Чига мужид оршин суугаа монгол судлаач ноён Кэнэцү Сасаки бол "Монгору цушин" сонины байнгын уншигч, идэвхтэй хамтран ажиллагчийн нэг юм. Тэрбээр тус сонины редакцитай байнгын холбоотой ажиллаж, сонины үг хэллэгийн талаар зөвлөлгөө өгч тусалдаг байна. Тухайлбал 2009 оны 10-р сарын сүүлчээр ирүүлсэн "Ан агнуурын тариф" гэдэг үгний "тариф"-ыг японоор нь шууд бичвэл япончууд ойлгоход бэрх тул "татвар", "хураамж" гэж орчуулан бичих нь зүйтэй шүү, үүнийг анхаараарай" гэжээ.

Бас монгол хэлний яам, газар, хэлтэс, тасаг, бүлэг, салбар, товчоо, агентлаг зэргийг хэрхэн яаж орчуулах талаар өөрийн санал бодлыг бичсэн байна.

Өвөр Монголын өөртөө засах орны Худалдааны газраас Бао Лидао гэдэг хүн 2010 оны 1-р сарын 4-нд "Менгу сяосибоо" сонины хамт олонд хандахдаа "Танай сонины агуулга улам бүр баяжиж, мэдээлэл нь арвижин цаг хугацаа алдалгүй уншигчдад хүрч байгаад баяртай байна. Дараа жил сониныг цахим хэлбэрээр үргэлжлүүлэн захиалах хүсэлтэй байна" гэж бичсэн байхад Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа "Монгол Тамхи" ХХК-ийн захирал ноён Ли Фэнбин "Менгу сяосибоо" сониныг би эртнээс захиалан уншиж байгаа, би монгол хэл мэддэггүй

учир Монголд болж буй үйл явдал, мэдээллийг зөвхөн тус сониноос олж авдаг. Сонины чанар, мэдээллийн агуулга сайжирч байгаад баяртай байна. Цаашид уншигчиддаа зориулж Монголын салбар бүрийн түүх, хөгжил дэвшлийг харуулсан мэдээ түлхүү оруулж өгвөл сайн байна” гэж 2009 оны 8-р сарын 23-нд бичсэн байна. “Их үйлсийн эрэлд” хэмээх нэртэй өөр нэг ХХК-ийн захирал ноён Жао Зирун гэдэг хүн “Би Монголд 2007 онд ирсэн. Тус сониноос гол мэдээллээ олж авдаг. Уншигчдын хувьд Монголын хууль дүрмийг танилцуулсан мэдээлэл их хэрэгтэй байдаг. 2007 оноос хойш Монголд их олон хууль батлагдаж, заримд нь өөрчлөлт орлоо шүү дээ. Тэр бүрийг тухай бүрт цаг алдалгүй олж авах нь хөрөнгө оруулагч бидний хувьд маш чухал байна” гэж 2009 оны 8-р сарын 23-нд сонины газарт ирүүлсэн захидалдаа хүсчээ. “Пушин Монгол” ХХК-ийн захирал ноён Цэнгэл “Би тус сонины байнгын уншигч. Монголд ажиллаж амьдарч байгаа хятадуудын хөрөнгө оруулсан байдал, Монголын эдийн засагт хэрхэн хувь нэмэр оруулж байгаа талаар мэдээ, сурвалжлага бэлдэж сониндоо оруулж байвал зүгээр санагддаг. Бидний тухай сайнаар бичээд, хийсэн бүтээснийг маань олж хараад олон түмэнд хүргээд ирвэл хөрөнгө оруулагчид илүү ихийг хийх хүсэлтэй болно гэдэгт итгэж байна” гэжээ. (2009 оны 8-р сарын 23.)

Эдгээр цөөн жишээ нь МОНЦАМЭ агентлагаас гадаадын түгээмэл хэлээр гаргаж буй сонин хэвлэлүүдийн нийтлэлийн үр нөлөөний талаар наад захын ойлголтыг та бүгдэд өгч байгаа болов уу гэж найдаж байна. “Новости Монголии”,

“Монгол мессенжер”, “Менгу сяосибоа” сонинууд нь өнөөдөр нэгэнт өөрийн гэсэн уншигчдын хүрээлэлтэй болж чадсан байна. Харьцангуй сүүлд гарсан “Монгору цушин” сониныг Японд хүмүүс мэддэг болж байна.

Мэдээллийн МОНЦАМЭ агентлаг нь 90 жилийн түүхтэй Монголын ууган хэвлэл, мэдээллийн хэрэгслийн нэг билээ. Тийм учраас үйл ажиллагааны арвин туршлага, баялаг уламжлалтай. Энэ тухай би урьд нь нэг бус удаа ярьж хэлж, бичиж шинжилж байсан. Зарим нэгээс нь товч дурдахад:

- “Хураангуй сэтгүүл” буюу “Бюллетень Монгольского Телеграфного Агентства” сонинууд нь Монголд цахилгаан мэдээний агентлагийн цоо шинэ маягийн хэвлэлийн үндэс суурийг тавьж хөгжүүлсэн юм.

- Энэ нь юуны түрүүнд түүний илүү дутуу үггүй товч тодорхой бичлэгийн хэлбэрээр илрэн гарч байв. Мэдээ мэдээллийн товч тодорхой хэлбэрийг Монголын сэтгүүл зүйд МОНЦАМЭ агентлаг жинхэнэ утгаар нь үүсгэн буй болгож, баяжуулан хөгжүүлсэн гэж үзэж болно.

- Эл товч тодорхой мэдээллүүд нь Цахилгаан мэдээний агентлагт шуурхай байдлаар баталгаажин тархаж байв. МОНЦАМЭ агентлаг нь Монголын сэтгүүл зүйд мэдээ мэдээллийн шуурхай чанарыг авчирч, түүний үнэ цэнийг хүн ардад мэдрүүлж чадсан юм. 1922-1923 онд долоо хоног тутамд нэгээс хоёр удаа шуурхай мэдээллийн сониныг монгол, орос хэл дээр зэрэгцүүлэн гаргаж байсан нь өнөөдрийн өдөр тутмын сонин хэвлэлтэй бараг адилхан гэж хэлж болно.

- Хамгийн бага зайд хамгийн өргөн агуулга бүхий багтаамжтай мэдээ мэдээллийг байршуулах сэтгүүл зүйн цоо шинэ зарчмыг МОНЦАМЭ агентлаг, түүний хэвлэлүүд Монголын сэтгүүл зүйд бий болгожээ. Ашигтай, идэвхтэй мэдээллийн зарчим анх түрүүнд "Бюллетень МОНТА", "Хураангуй сэтгүүл"-д хэрэгжсэн байна.

- МОНЦАМЭ агентлаг Монголын хэвлэлийн түүхэнд анх удаа улс орны гадаад сурталчилгааг үүсгэн буй болгож хөгжүүлсэн түүхтэй. Монголын тухай гадаад сурталчилгааг сэтгүүл зүйн мэргэжлийн төвшинд эхлүүлж хөгжүүлсэн Монголын анхны хэвлэл бол "Бюллетень Монгольского Телеграфного Агентства" сонин юм. МОНЦАМЭ агентлаг нь тухайн цаг үед буюу XX зууны эхэн үеэс наяд оны сүүлч хүртэлх хугацаанд гадаадынхны хувьд Монголыг олж харах цорын ганц цонх болж байсан билээ.

- МОНЦАМЭ агентлаг үүсэн буй болсон цагаасаа эхлэн мэдээ мэдээллийг төрөлх эх хэлээрээ явуулж, бичиг соёлынхоо яруу тансаг уламжлалд тулгуурлан сурталчилсан өвөрмөц онцлогтой. Үүний яруу тодорхой жишээ нь "Хураангуй сэтгүүл"-ийн хэл хэллэг, дүр дүрслэл юм.

- Хамгийн товч мэдээнээс эхлээд дэлгэрэнгүй сурвалжлага, тайлан, асуудал хөндсөн хурц өгүүлүүд, захидал, тэмдэглэл, зураглал хүртэлх сэтгүүл зүйн бүх төрөл зүйлийг "Хураангуй сэтгүүл", "Бюллетень Монгольского Телеграфного Агентства" сонин гүйцэд ашиглаж чаддаг байв. МОНЦАМЭ агентлаг үүгээрээ Монголын сэтгүүл зүйн төрөл зүйлүүдийг хөгжүүлэхэд хүндтэй үүрэг гүйцэтгэсэн юм. Сонины дэглэлт, өнгө

будаг, макет, чимэглэл, дизайны талаарх шинэчлэгч уур амьсгалыг Монголд анх түрүүнд нэвтрүүлэгч нь мөн л "Бюллетень Монгольского Телеграфного Агентства" сонин байсан билээ.

- Дэлхий дахины байдал, таван тивийн улс орнуудын хөгжил дэвшил, хүн ардын амьдрал тэмцлийн талаарх хамгийн шинэ мэдээ, мэдээллийг монголчуудад МОНЦАМЭ агентлаг анхлаж системтэй бөгөөд тасралтгүй хүргэж эхэлсэн түүхэн гавьяатай. Их зохиолч Дашдоржийн Нацагдоржийн оновчтой тодоор зүйрлэн хэлсэнчлэн "Хөмөрсөн тогоо шиг харанхуй бүдүүлэг Монгол орны хуучин хүү" нарт энэ нь алтан нарны гэрэл, мөнгөн сарны туяа адил оюуны түнэр харанхуйг гийгүүлэн, танин мэдүүлж, соён гэгээрүүлэгч туйлын хэрэгтэй зүйл байсан юм.

- МОНЦАМЭ агентлагаас эрхлэн гаргаж байсан хэвлэлүүд нь нэг талаас Монголын сэтгүүл зүйн өмнөх үеийн дэвшилт уламжлалыг тууштай үргэлжлүүлэхийн хамт нөгөө талаас Европын, ялангуяа Оросын сэтгүүл зүйн хөгжлийн шинэ чиг хандлагыг Монголд нэвтрүүлж, түүний цаашдын хөгжилд хүчтэй түлхэц үзүүлсэн байна. "Бюллетень Монгольского Телеграфного Агентства" сонинд орос, гүрж ястан үндэстэн ажиллаж байсан нь ийм боломжийг бүрдүүлсэн бөгөөд Монголын тухайн үеийн сэтгүүлчдэд арга зүйн чухал ач холбогдолтой байв. "Бюллетень Монгольского Телеграфного Агентства", "Хураангуй сэтгүүл" сонин бол Европын сонгодог сэтгүүл зүйн үндсэн зарчмуудыг Монголд нэвтрүүлэн хөгжүүлсэн сонинууд юм.

- МОНЦАМЭ-гийн ууган хэвлэлүүдийн бусдаас ялгарах онцлог нь шинэ

үзэл санаа, дэвшилт зүйлс, шинжлэх ухааны ололт амжилт, нийгмийн дэвшлийг тууштай сурталчлан дэлгэрүүлэгч чанар байсан гэж бүрэн үндэстэй хэлж болно.

- Нийгмийн хөгжил дэвшилд саад тотгор болсон бүхнийг хайр найргүй илчлэн шүүмжлэж байснаараа "Хураангуй сэтгүүл", "Бюллетень МОНТА" сонин тухайн цаг үедээ бусдаас онцгойрон ялгарч байв.

- Эдгээр хэвлэл нь зөвхөн мэдээлэгч төдийгүй танин мэдүүлж соён гэгээрүүлэгч, нийгэмд удирдлагын хэрэгслийн үүрэг гүйцэтгэгч, зохион байгуулагч, иргэд олон түмнийг сайн үйлсийн жишээгээр хүмүүжүүлэгч, нийгэм болоод иргэдийн хооронд юугаар ч сольшгүй харилцааны үүрэг гүйцэтгэгч сонинууд байсан юм.

- МОНЦАМЭ агентлаг, түүний хэвлэлүүд нь үүсэн буй болсон цагаасаа эхлэн үнэн бодит байдлыг үйл ажиллагаандаа ягштал баримтлагчид байлаа. Баталгаатай эх сурвалж, баримтын хөдөлшгүй үнэн бодит зарчим нь дэлхийн бүх улс орны мэдээллийн агентлагуудын нийтлэг жишиг, түүний дотор МОНЦАМЭ агентлагийн үндсэн зарчим хэвээрээ байна.

- "Бюллетень МОНТА", "Хураангуй сэтгүүл" нь "Шинэ толь хэмээх бичиг", "Нийслэл Хүрээний сонин бичиг" сонины чөлөөт, дэвшилт уламжлалыг өвлөсөн хэвлэлүүд бөгөөд түүний тэрхүү эрхэм нандин уламжлалыг өнгөрсөн зууны наяд оны сүүлч, 90-ээд оны эхээр МОНЦАМЭ-гийн "Цаг үе" сэтгүүл, "Ил товчоо" сонин зэрэг бусад хэвлэл үргэлжлүүлсэн түүхтэй билээ.

Энэ мэтээр өнгөрсөн түүхэн уламжлалаас цөөнгүй зүйлсийг нэрлэн хэлж

болно. Эдгээр нь МОНЦАМЭ агентлаг, түүний ууган хэвлэлүүдийн үйл ажиллагаанд хуримтлагдсан арвин баялаг туршлага, өвөг дээдсээс бидэнд гэрээсэлж үлдээсэн өв хөрөнгө, үнэт нандин зүйлс юм. Тэрхүү уламжлалыг өнөөгийн МОНЦАМЭ агентлагийнхан өвлөн уламжлахын зэрэгцээ юугаар яаж баяжуулж, хөгжүүлж байна вэ гэдэгт одоо хариулах гэж оролдоод үзье. Гурав, дөрөвхөн зүйлийг онцлон дурдахыг хүсч байна. Үүнд:

- Юуны түрүүнд өмнөх уламжлал дээрээ тулгуурлан үйл ажиллагаагаа тууштай үргэлжлүүлж, хөгжүүлж байна гэж хэлмээр байна. Өчигдөргүй өнөөдөр, өнөөдөргүй маргааш гэж байхгүй. МОНЦАМЭ агентлагийн үүх түүхийн эрэл хайгуулыг бид сүүлийн арван жилийн турш тасралтгүй үргэлжлүүллээ. Хэд хэдэн ном гаргаж, эрдэм шинжилгээний хурал, дугуй ширээний ярилцлага зохион байгууллаа. Түүний нэг нь өнөөдрийн энэ арга хэмжээ юм. Өнгөрсөн түүхийг ухан онгичих тусам шинэ шинэ баримт материал гарч ирсээр байна. 1921 оны 7-р сарын 19-нд Ардын Засгийн газрын шийдвэрээр анх үүсэн байгуулагдсан МОНЦАМЭ агентлагийн эхлэл Богд хаант Засгийн газрын өмнөх он жилүүд рүү гулсан шилжиж ч болзошгүй байдалтай байна.

- Уламжлал дээрээ тулгуурлаж шинэчлэгдсэн МОНЦАМЭ агентлагийн мэдээ, мэдээлэл өдөр шөнийн 24 цагийн турш тасралтгүй гадагшаа ба дотогшоо гэсэн хоёр урсгалаар үргэлжилж байна гэж дээрх асуултад нэмж тодотгон хариулмаар байна. Өнөөдөр МОНЦАМЭ агентлаг гадаадын улс орнуудаас өдөрт дунджаар 1000 мэдээ мэдээлэл хүлээн

авч эх хэл рүүгээ түүвэрлэж хөрвүүлээд нийт хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдэд түгээж байна. Жилд 252.000 гарчиг мэдээ мэдээлэл хүлээн авч байна.

- Монгол Улс, Монголын ард түмний тухай англи, орос хэлээр өдөр тутмын "МОНЦАМЭ-гийн мэдээ" товхимол бэлтгэж, гадаадын мэдээллийн агентлагуудад өдөрт дунджаар 35 мэдээ мэдээллийг багцлан илгээж байна. Энэ нь жилд англиар 4500, оросоор 3600 гарчиг мэдээ, мэдээлэл болж байгаа болно. МОНЦАМЭ агентлагийг 2005 ба 2008 онд МСНЭ-ээс Монгол Улсыг гадаадад үр бүтээлтэй сурталчлан таниулагч оны шилдэг мэдээллийн байгууллагаар шалгаруулж, "Mongolia today", ("Өнөөгийн Монгол Улс") сэтгүүлийг 2009 онд "Оны шилдэг сэтгүүл"-ээр өргөмжилсөн нь санамсаргүй тохиолдол байгаагүй юм.

- "МОНЦАМЭ мэдээ" сониноо бид өдөр тутам 16 нүүрээр гаргаж нийслэл Улаанбаатар хот болон 21 аймгийн иргэдэд хүргэж байна. Мэдээллийн тэнцвэртэй байдал, сэдвийн тусгагдахууны харьцаа, газар нутгийн байршил зэрэгт онцгойлон анхаарч ажилладаг болсныг хамтад тэмдэглэх нь зүйтэй болов уу.

- 2010 оноос МОНЦАМЭ агентлаг дүрст мэдээллийн шинэ горимд шилжиж байна. Ингэснээр гадаадын мэдээллийн агентлагуудад Монголын тухай түгээмэл гадаад хэлээр дүрстэй мэдээллийг нийлүүлдэг болно. Өөрөөр хэлбэл МОНЦАМЭ агентлагийн гадаад сурталчилгаанд чанарын ахиц гарна гэсэн үг юм.

- МОНЦАМЭ агентлаг, тус агентлагаас эрхлэн гаргаж буй сонин, сэтгүүлд ажиллагч уран бүтээлчид ёс зүйтэй, хариуцлагатай сэтгүүл зүйг Монголд

хөгжүүлэхийн төлөө хичээнгүйлэн зүтгэж байгааг нэмж хэлье. Энэ бол манайхны хувьд өмнөх уламжлал, үнэт зүйлсийнх нь үргэлжлэл болж байгаа юм. Тийм ч учраас МОНЦАМЭ агентлагийн хамт олон Монгол дахь чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээс анх түрүүнд буюу 2001 онд өөрсдийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг тодорхойлж, энэ тухайгаа өргөн олон нийтэд нэр төртэйгээр ил тодоор зарлан тунхагласан билээ. Энэ бол "МОНЦАМЭ-гийн алтан дүрэм" буюу манайхны ёс зүйн зарчим юм.

МОНЦАМЭ-гийн АЛТАН ДҮРЭМД:

Нэг

Шуурхай, хамгийн шуурхай, бүхнээс шуурхай

Хоёр

Товчхон, аль болох товчхон, бүр товчхон

Гурав

Үнэн, бодит үнэн, гагцхүү үнэн

Дөрөв

Баталгаатай эх сурвалжтай, баримт нотолгоотой

Тав

Гарчиг содон, лид оновчтой, сэдэв шинэлэг

Зургаа

Хэл хэллэг чихнээ чимэгтэй, нүднээ тусгалтай

Долоо

Дүр дүрслэл яруу бөгөөд уран

Найм

Утга санаа тодорхой, тов тодорхой

Ес

Ойлгомжтой, ой тойнд шингэж үлдэхүйц цэгцтэй

хэмээн бичээстэй байдаг бөгөөд бүх уран бүтээлчид нь үүнийг үйл ажиллагаандаа ёсчлон хэрэгжүүлж байдаг билээ.

Эцэст нь энэ бүгдийг нэгтгэж ХХ зууны эхэн үеийн Монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулж байсан МОНЦАМЭ-гийн хэвлэлүүд өнгөрсөн зууны 90-ээд онд Монголд өрнөсөн хувьсгалт өөрчлөлт шинэчлэлд дуу хоолойгоо мөн нэгэн адил нэгтгэж Монголд чөлөөт хэвлэл жинхэнэ утгаараа бүрэлдэн төлөвшихөд жинтэй түлхэц үзүүлсэн бөгөөд өнөөдөр ч ийм хэвээрээ байна гэсэн дүгнэлтийг хийж байна.

“МОНЦАМЭ мэдээ” өдөр тутмын сонин, “Хүмүүн бичиг” болон “Монгол мессенжер”, “Новости Монголии”, “Менгу сяосибо”, “Монгору цушин” долоо хоног тутмын сонинууд, “Өнөөгийн Монгол Улс” улирал тутмын сэтгүүл, тэрчлэн орос, англи хэл дээр өдөр тутам бэлтгэдэг “МОНЦАМЭ-гийн мэдээ” товхимлын хувьд чөлөөт хэвлэлийн өмнөх үеийн үзэл санаа, уламжлалыг үргэлжлүүлж үйл ажиллагаандаа сэтгүүл зүйн үндсэн үүрэг, зарчмуудыг ягштал мөрдөж ажиллах нь эрхэм ариун үүрэг, тулгамдсан хойшлуулшгүй зорилт, нэр төрийн хэрэг болж байна. Зарим тулгамдсан зорилтыг бага зэрэг тодруулж задлан дэлгэрүүлж ярих нь зүйтэй бизээ. Тухайлбал:

- “МОНЦАМЭ мэдээ” нийгэм дэх нэр хүндтэй, буурь суурьтай сонин гэж өөрийгөө хэрэв үзэж байгаа бол далайцтай, даацтай нийтлэлүүдийнхээ тоо хэмжээг мэдэгдэхүйц нэмэгдүүлж нийгмийн удирдлагын хэрэгсэл болох үүргээ эрс сайжруулах шаардлагатай юм. үрээлэн байгаа байгаль орчныг хайргдан хамгаалж, Монгол дахь цөлжилтийн хүрээг багасгах зорилгоор

улс орон даяар бүх нийтээр мод, бутарьж “Дэлхий ээжээ дээдлэн хүндэтгэдэг өдөртэй болцгооё” гэсэн уриалгаа улам олон хүнд хүргэж төр, засгийн удирдлагын төвшинд шийдвэр гаргуулан хэрэгжүүлэх чиглэлээр тууштай ажиллах хэрэгтэй болно. Үүнд нийтлэлийн цэгцтэй, нарийвчлан боловсруулсан бодлого, хүчин чармайлт, хөөцөлдлөг зайлшгүй шаардлагатай. Бас Монгол Улсын төрийн хэлний зөвлөлтэй хамтран зохион байгуулж байгаа өргөн хэрэгцээний зарим гадаад үгийг төрөлх монгол хэлээрээ хэлж, ярьж, бичиж хэвшүүлэх хүчин чармайлтынхаа эрч хүчийг сулруулахгүйгээр харин ч чангаруулах зорилт аяндаа тулгарна. Өөрөөр хэлбэл нийгмийн хурц, тулгамдсан асуудлуудыг зоригтой хөндөж, түүндээ бүх нийтийн анхаарлыг хандуулан дэмжлэг авч нийтлэлийн тодорхой үр дүнд хүрэхийг чухалчлах нь “МОНЦАМЭ мэдээ” сонины тэргүүн зэргийн зорилт болж байна. Асуудал дэвшүүлэн өгүүллүүдийнхээ мөрөөр уйгагүй ажилаж, сэдвийнхээ хүрээг өргөжүүлэн иргэдийн оролцоог нэмэгдүүлж байж сая үр дүнд хүрэх болно.

- “МОНЦАМЭ мэдээ” сонинд ажиллаж буй сэтгүүлчдийн бичлэгийн үр чадвар, эх хэлний мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх нь мөн л тулгамдсан зорилтын нэг юм. Монголын чөлөөт хэвлэлийн сүүлийн хорин жилийн практикаас харахад сэтгүүлч хүн сэтгүүл зүйн бүх төрөл зүйлээр бичиж чаддаг байх ёстой. Тэгэхдээ бичлэгийн нэг төрлөөр дагнаж мэргэших нь илүү амжилтад хүрэх үндэс суурь болж байна гэдэг нь улам бүр тод мэдрэгдэж байна. Үүний наад захын баримт бол “Өдрийн шуудан”-гийн Б.Ганчимэгийн ярилцлага, “Өнөөдөр”

сонины Р.Эмүжингийн улстөрийн нийтлэлүүд юм. Ур чадварын ундарга нь эх хэл, эх хэлээрээ нээж үзүүлсэн уран сайхны дүр дүрслэл болж байна.

- Даацтай бөгөөд далайцтай, нийгмийн хурц асуудлыг хөндсөн нийтлэлийг сэтгүүлчийн дан ганц онгод, авьяас билэгт найдаад орхих нь учир дутагдалтай юм. Зах зээлийн эдийн засгийн харилцааны өнөө үед Монголын сэтгүүл зүйд өндөр мэдлэг боловсролтой, тодруулж хэлбэл тал бүрийн шинжлэх ухааны нарийн мэдлэг эзэмшсэн нийтлэлчид шаардлагатай, улам бүр эрэлт хэрэгцээтэй болж байна. Өөрөөр хэлбэл хос мэргэшил эзэмшихийг аж төрж буй цаг үе нь сэтгүүлчдээс нэхэн шаардаж байна гэсэн үг юм. МОНЦАМЭ агентлагийн олон улсын тоймч, "МОНЦАМЭ мэдээ" сонины улстөр, эдийн засгийн тоймчдод, бусад бүх уран бүтээлчдэд энэ нь шууд хамаарна. Эдийн засагчид, улстөрч нийгмийн зүтгэлтнүүд, соёл, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын мэргэжилтнүүдийг нийтлэлийнхээ үйл ажиллагаанд татан оролцуулах зайлшгүй шаардлага тулгарна.

Монголын ард түмний түүх, соёлын үнэт өв, тусгаар тогтнолын билэг тэмдэг болсон монгол бичгийг нийт иргэд, тэргүүн ээлжинд хүүхэд багачууд, залуусын дунд дэлгэрүүлж сургаж хөгжүүлэх таатай орчинг бүрдүүлэх явдал бол "Хүмүүн бичиг" сонины эрхэм дээд зорилго болох нь бүгдэд ойлгомжтой. Энэ зорилтыг ямар аргаар яаж хэрэгжүүлэх вэ гэдэг нь тус сонины редакцийн нийтлэлийн бодлогын цөм асуудал болно. Монголын сайхан бичигтнүүдийн улсын уралдаан зарлан дүгнэж урамшуулах, сайхан бичгийн хуулан бичлэгийг сонины

нүүрэнд тогтмол явуулах зэрэг өнгөрсөн 18 жилийн практикаар шалгарсан сайн уламжлалаа улам бататгахдаа нэгэн хэвийн хэвшмэл арга барилд хүлэгдэж баригдалгүйгээр уншигчдын сонирхол татахуйц нийтлэлийн шинэ сонин хэлбэрүүдийг эрж хайж нэвтрүүлэх явдал тун чухал юм. Монголын сэтгүүл зүйг үндэслэгч их соён гэгээрүүлэгч эрдэмтэн Жамсраны Цэвээн 1913 оны "Шинэ толь хэмээх бичиг" сониндоо И.Крыловын ёгт үлгэрүүд, Л.Толстойн өгүүллэгүүдээс эх монгол хэлээрээ яруу тансгаар хөрвүүлэн нийтэлж байсан бэлээхэн жишээ ч байж байна.

Түгээмэл гадаад хэлээр гарч байгаа "Монгол мессенжер", "Новости Монголии", "Менгу сяосибо", "Монгору цушин" сонин, "Mongolia today" сэтгүүл, "МОНЦАМЭ-гийн мэдээ" товхимлуудын хувьд бол ардчилсан Монгол Улсын тухай үнэн бодит мэдээллийг гадаадын уншигчдад өдөр, долоо хоног, улирал тутам тасралтгүйгээр түргэн шуурхай хүргэх явдал гол зорилт байхын зэрэгцээ тэргүүн ээлжинд:

- Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас батлан гаргаж буй шинэ хуулиуд, дүрэм журмыг шуурхай мэдээлэн гадаадын уншигчдад ойлгуулж таниулах,

- Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтын таатай орчин бүрэн бүрдсэнийг системтэй сурталчлах,

- Монгол оронд зэс, алт, мөнгө, уран, нүүрс зэрэг ашигт малтмалын шинэ шинэ ордууд нээгдэж байгааг тоо баримтаар мэдээлж хөрөнгө оруулагчдын анхаарлыг Монголд хандуулах,

- Монгол Улсын унаган байгалийн гоо үзэсгэлэн, түүх соёлын гайхамшиг, нүүдэлчдийн соёл иргэншлийн давтаг-

дашгүй өвөрмөгц онцлогийг байнга сурталчилж гадаадын аялал жуулчлалын урсгалыг Монгол руу татах,

- Шинэ үеийн шинэ монгол хүнийг гадаадын уншигчдад үнэн бодитой бөгөөд үнэмшилтэйгээр тал бүрээс нь нээн үзүүлэх зэрэг нийтлэлийн олон сэдвүүд байна.

Сэтгүүл зүйн шинжлэх ухаанд нийтлэлийн үр нөлөө, үр ашиг гэсэн үндсэн гол ойлголт бий. Нийтлэл, нэвтрүүлэг үр нөлөөтэй, үр ашигтай болж чадаж байна уу, үгүй юу гэдгийг үнэлж дүгнэдэг практик шалгуурууд ч байдаг билээ. Тийм болохоор аль ч сонин, сэтгүүлийн редакци нийтлэлийнхээ үр нөлөөг, улмаар үр ашгийг тасралтгүй дээшлүүлж, тодорхой үр дүнд хүрэхийг эрмэлзэн ажилладаг нь хэнд ч нууц биш юм. Эх хэлээрээ болоод түгээмэл гадаад хэл дээр хэвлэгддэг МОНЦАМЭ-гийн бүх сонин, сэтгүүлд энэ нь мөн нэгэн адил хамаарна. Харин тэрхүү нийтлэлийн үр нөлөө, үр ашгийг хэрхэн яаж, ямар аргаар ахиулж дээшлүүлэх нь тухайн редакцийн нийтлэлийн шинжлэх ухааны үндэслэлтэй ухаалаг бодлогоос шууд шалтгаалдаг байна. Нийтлэлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжүүлэлтэд сэтгүүл зүйн шинжлэх ухааны үүднээс нухацтай бөгөөд бодлоготойгоор хандаж сурцгаая гэж уриалмаар байна.

Ишлэл

¹ Баасансүрэн Т. 2009. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвш-

сен нь. XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл. Тэргүүн дэвтэр (I хэсэг). УБ., 194-250 дахь тал.

² Ганди Т. 2009. Европчууд аймхай хүмүүс. УБ., 215-216 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. 2004. "Үнэн-20000" эмхтгэл. УБ.
2. Баасансүрэн Т. 2009-2010. Монголд чөлөөт ардчилсан хэвлэл бүрэлдэн төлөвшсөн нь. XX зууны эхэн үеийн Монголын чөлөөт хэвлэл. 5 боть. УБ.
3. Зульфакфиль М. 2004. Сэтгүүл зүйн онолын үндэс. 2004.
4. Норовсүрэн Л. 2000, 2001, 2003. Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм. I, II, III боть. УБ.
5. Норовсүрэн Л. 2004, 2005, 2007. Монголын нийтлэл. I, II, III боть. УБ.

Резюме

В данной статье автор подробно излагает периодические издание, выпускаемые информационным агентством МОНЦАМЭ. Агентство, основанное 19 июля 1921 года, с первых дней своего существования преследовало две главные цели — обеспечение информационной потребности населения и пропаганда собственной страны за рубежом. Для последней цели МОНЦАМЭ, начиная с 25 мая 1922 года, выпускал газету "Бюллетень Монгольского Телеграфного Агентства", которая является пионером в этой отрасли. В настоящее время информационным агентством МОНЦАМЭ выпускаются девять изданий на русском, английском, китайском и японском языках. Автор на основании данных социологических исследований излагает свои мысли о актуальных проблемах и перспективах развития этих изданий.